

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариуг сонгоорой.

1. Монгол орны баруун захын цэг аль нь вэ? /1 оноо/
- A. Өвөрхөшөөтийн булаг B. Монгол Шарын даваа
C. Орвог Гашууны Бор толгой D. Соёлз уулын Модтой Хамар даваа
E. Таван Богдын Мааньт уул

2. Масштабыг бичиглэх хэлбэрээр нь ангилсан бүдүүвчийг гүйцээж нөхөөрэй. /1 оноо/



- A. Жижиг масштаб
B. Үсгэн масштаб
C. Тойргон масштаб
D. Босоо масштаб
E. Шугаман масштаб


3. Тэмээн сүргийн тоо толгойгоор тэргүүлэгч аймаг аль нь вэ? /1 оноо/
- A. Хөвсгөл B. Өвөрхангай C. Булган D. Өмнөговь E. Говь-Сүмбэр

4. Монгол орны агаарын үнэмлэхүй их температур хаана бүртгэгдсэн бэ? /1 оноо/
- A. Эхийн гол B. Дархадын хотгор C. Чойр D. Хүрэнбэлчир E. Улз гол

5. Өдөр шөнө солигдох шугам нь уртрагийн хэдэн градус вэ? /1 оноо/
- A. 0° B. 90° C. 45° D. 180° E. 66,5°

6. Нарны найрлагын 70%-ийг эзлэх химийн элемент аль нь вэ? /1 оноо/
- A. Нүүрстөрөгч B. Хүчилтөрөгч C. Устөрөгч D. Азот E. Гели

7. Дараах таних тэмдэг газарзүйн зурагт юуг илэрхийлэх вэ? /1 оноо/



- A. Далан
B. Гуу, жалга
C. Өндөр хүчдэлийн шон
D. Тариан талбай
E. Навчит ой

8. Далайн усны найрлагад зонхилох давсыг сонгоно уу. /1 оноо/
- A. Фторт натри B. Бромт кали C. Хоолны давс D. Сода E. Хлорт кали

9. Мөсөөр хучигдсан хуурай газрыг сонгоно уу. /1 оноо/
- A. Австрали B. Еврази C. Африк D. Хойд Америк E. Антарктид


10. Тайширын усан цахилгаан станц аль аймагт байдаг вэ? /1 оноо/
- A. Говь-Алтай B. Өвөрхангай C. Дорнод D. Өмнөговь E. Сүхбаатар

11. Дархад ястны олонх нь амьдардаг аймаг аль нь вэ? /1 оноо/
- A. Говь-Алтай B. Дундговь C. Өвөрхангай D. Хөвсгөл E. Хэнтий



12. Эрдэнэт хот нь аль эдийн засгийн бүс нутгийн тулгуур төв вэ?

/1 оноо/



- A. Улаанбаатарын
- B. Хангайн
- C. Баруун
- D. Зүүн
- E. Төвийн

13. Нарны аймгийн хамгийн том гарагийг сонгоорой.

/1 оноо/

- A. Ангараг
- B. Далай ван
- C. Сугар
- D. Бархасбадь
- E. Дэлхий

14. Хуурай газрын хамгийн нам дор газарт орших дэлхийн хамгийн их давсжилттай нуурыг олно уу.

/1 оноо/

- A. Хөвсгөл
- B. Сөнөсөн тэнгис
- C. Арал тэнгис
- D. Титикака
- E. Гурон

15. Цэг маягийн байршилтай хотууд бие биетэйгээ нийлж, их талбай эзлэн орших хот суурингийн орчин үеийн төвлөрөл үүсгэснийг юу гэж нэрлэдэг вэ?

/1 оноо/

- A. Агломераци
- B. Дагуул хот
- C. Бүлэг тосгон
- D. Хотын тэсрэлт
- E. Хуурамч хотжилт

16. Говь Алтай нурууны ноён оргилыг сонгоорой.

/1 оноо/

- A. Баянцагаан
- B. Сэврэй
- C. Их Богд
- D. Ноён
- E. Арц богд

17. Цөлийн бүсийн амьтныг сонгоорой.

/1 оноо/



- A. Тоншуул
- B. Булга
- C. Цаа буга
- D. Хандгай
- E. Мазаалай

18. Хэнтий нуруунаас эх авч БНХАУ-ын Далай нуурт цутгадаг, Номхон далайн ай савд хамаарагдах голыг сонгоно уу.

/1 оноо/

- A. Онги
- B. Хэрлэн
- C. Аргуй
- D. Идэр
- E. Орхон

19. Төмөрлөг ашигт малтмалын төрөлд аль нь багтах вэ?

/1 оноо/

- A. Газрын тос
- B. Гөлтгөнө
- C. Шөрмөсөн чулуу
- D. Фосфорит
- E. Зэс

20. 1981 онд байгуулагдсан ямааны ноолуурыг боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний хөнгөн үйлдвэрийн томоохон компанийг сонгоно уу.

/1 оноо/

- A. Монросцветмет
- B. Скайтел
- C. Говь
- D. Эрдэнэт хивс
- E. Алтанбулаг

21. 6-р сарын 22-нд нар хаана эгц тусах вэ?

/1 оноо/

- A. Мэлхийн зам
- B. Матрын зам
- C. Экватор
- D. Хойд туйл
- E. Өмнөд туйлын цагариг



22. Өндөр хөгжилтэй орон аль нь вэ? **/1 оноо/**
 А. Чад В. Колумб С. Лаос Д. Гана Е. Франц

23. Цөлжилт үүсгэж буй байгалийн хүчин зүйлийг нэрлэнэ үү. **/1 оноо/**
 А. Ойн зохисгүй ашиглалт В. Бэлчээрийн талхлалт С. Усны зохисгүй хэрэглээ
 Д. Уул уурхайн зохисгүй олборлолт Е. Удаан хугацааны ган

24. Бразил, Парагвай, Аргентин улсуудын нутгаар дамжин урсдаг мөрөнг сонгоно уу. **/1 оноо/**
 А. Миссури В. Амазонк С. Оринок Д. Миссисипи Е. Парана


25. Багахангай өртөөнөөс салаа төмөр замаар аль сууринд очих боломжтой вэ? **/2 оноо/**



- А. Багануур
 В. Алтанбулаг
 С. Бор-Өндөр
 Д. Зүүнбаян
 Е. Эрээнцав

26. Их Британи улсад үүсдэг гамшигт үзэгдэл нь 1000 гаруй километрийн алсад орших Скандиновын хойгт ой мод устгах, усны амьтан, ургамал мөхөх аюулд хүргэх үндсэн нөхцөл болсон бол уг шалтгааныг сонгоно уу. **/2 оноо/**
 А. Цунами В. Хар салхи С. Үер Д. Хүчлийн бороо Е. Шороон шуурга

27. Дараах улс орнуудын нутаг дэвсгэрийн газарзүйн зургийг ажиглаад аль нь Чили улс болохыг тодорхойлно уу. **/2 оноо/**



28. Өндөр уулын бүслүүр, мөнх цас, эмчилгээний рашаанууд болон Алтайн ирвэсний гол байршил нутгийг хамгаалах үндэслэлээр 2000 онд улсын тусгай хамгаалалтад авсан газрыг сонгоно уу. **/2 оноо/**
 А. Хан Хэнтий ДЦГ В. Цамбагарав БЦГ С. Яхь нуур БНГ
 Д. Хустайн нуруу БЦГ Е. Хорьдол Сарьдаг ДЦГ

29. Та Австрали тивд аялахдаа доорх уугуул иргэдийн алиных нь соёл, зан заншил, ахуй амьдралтай танилцаж судалгаа хийх вэ? **/2 оноо/**
 А. Аброген В. Индиан С. Бушмен Д. Эксимос Е. Бербер

30. Газарзүйн зурагт тэмдэглэсэн А цэгийн байршил дээрх газрын нэрийг олоорой. **/2 оноо/**



- А. Их Элсэн цөл
 В. Тасман арал
 С. Дарвин хот
 Д. Косцюшко оргил
 Е. Эйр нуур

31. Зургийг ажиглаад билгийн тооллын хэдний сар болохыг тодорхойлно уу. **/2 оноо/**



- A. Хуучдын хорин таван
- B. Шинийн дөрвөн
- C. Шинийн арван таван
- D. Хуучдын арван найман
- E. Шинийн долоон

32. Элсэн чулуу өндөр температур, даралтын нөлөөгөөр хувирч ямар хувирмал чулуулаг үүсэхийг тодорхойлно уу. **/2 оноо/**

- A. Галт уулын хөөс
- B. Хүлэр
- C. Кварцит
- D. Давс
- E. Нүүрс

33. Байгалийн төрх байдлыг голлон ургадаг ургамалтай нь зөв тохируулаарай. **/2 оноо/**

1	Говь	a	Тоорой
2	Тайга	b	Агь
3	Хээр	c	Хуш
4	Таг	d	Арц

- A. 1-d, 2-c, 3-b, 4-a
- B. 1-a, 2-c, 3-b, 4-d
- C. 1-c, 2-a, 3-d, 4-b
- D. 1-b, 2-a, 3-c, 4-d
- E. 1-b, 2-d, 3-a, 4-c

34. “Google earth” программаас авсан зургийг ажиглаад 1 дугаараар тэмдэглэсэн нуур аль нь болохыг олоорой. **/2 оноо/**



- A. Бөөнцагаан нуур
- B. Далай нуур
- C. Хяргас нуур
- D. Толбо нуур
- E. Хар-Ус нуур

35. 25°C температуртай агаарын харьцангуй чийг 55% байсан бол үнэмлэхүй чийгийн хэмжээг олоорой. (Үнэмлэхүй чийгийн багтаамж 23,8гр/м³) **/2 оноо/**

- A. 16гр/м³
- B. 10гр/м³
- C. 2гр/м³
- D. 13гр/м³
- E. 5гр/м³

36. Өмнөговь аймгийн Гурван тэс суманд оршдог 125.5 сая тонн нүүрсний судлагдсан нөөцтэй стратегийн орд газрыг сонгоно уу. **/2 оноо/**

- A. Бүрэнхаан
- B. Цагаан Суварга
- C. Бороо
- D. Нарийн Сухайт
- E. Баянтээг

37. Улс орнуудыг засаглалын хэлбэртэй нь зөв харгалзуулна уу. **/2 оноо/**

1. Итали	a. Үндсэн хуульт хаант засаглал
2. Андорра	b. Парламентийн БН засаглал
3. АНУ	c. Ерөнхийлөгчийн БН засаглал
4. Тайланд	d. Хэмжээгүй эрхт хаант засаглал

- A. 1-a, 2-b, 3-d, 4-c
- B. 1-b, 2-d, 3-c, 4-a
- C. 1-d, 2-c, 3-b, 4-a
- D. 1-b, 2-c, 3-a, 4-d
- E. 1-a, 2-d, 3-c, 4-b


38. 1949 онд байгуулагдсан. Төв нь Бельгийн Брюссельд байрладаг. Гишүүн улсуудын эрх чөлөө, аюулгүй байдлыг улс төр, цэрэг зэвсгийн хүчээр хангах, бүс нутагтаа шударга ёс, энхтайван, ардчилал, хүний эрх чөлөөг эрх зүйт төрийн үндсэн дээр бэхжүүлэх зорилготой цэрэг улс төрийн байгууллагыг сонгоорой. **/2 оноо/**

- A. Европын холбоо
- B. Умард Атлантын гэрээ
- C. Дэлхийн банк
- D. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага
- E. Дэлхийн худалдааны байгууллага



39. Хотгор гүдгэрийн хэлбэрийг хаялбар шугамаар зөв дүрсэлсэнтэй нь харгалзуулна уу.


/2 оноо/



- A. 1-с, 2-а, 3-d, 4-b
- B. 1-d, 2-а, 3-b, 4-с
- C. 1-с, 2-b, 3-d, 4-а
- D. 1-d, 2-с, 3-b, 4-а
- E. 1-b, 2-а, 3-d, 4-с

40. Хот байгуулалтын олон цөмт хэлбэрийг дүрсэлсэн зурагт 7 дугаараар ямар дүүргийн байршлыг харуулсан байна вэ?

/2 оноо/



- A. Баячуудын хороолол
- B. Захын бизнес дүүрэг
- C. Орлого багатай иргэдийн орон сууцны хороолол
- D. Төвийн бизнес дүүрэг
- E. Дундаж орлоготой иргэдийн хороолол


41. Дулаан болон чийгийн хувьд улирлын ялгаагүй, гилей гэж нэрлэгддэг мөнх ногоон ой тархсан газарзүйн бүслүүр аль нь вэ?

/2 оноо/

- A. Дулаан бүслүүр
- B. Халуун бүслүүр
- C. Экваторын бүслүүр
- D. Сэрүүн бүслүүр
- E. Туйлын бүслүүр

42. Дэлхийн худалдааны газарзүйн зурагт ямар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ болон экспорт, импортын чиглэлийг дүрслэн харуулсан байна вэ?


/2 оноо/



- A. Чихрийн манжин, нишингэ
- B. Газрын тос
- C. Нүүрс
- D. Цагаан будаа
- E. Байгалийн хий

43. Дараах график нь аль хотын уур амьсгалыг илэрхийлж байна вэ?

/2 оноо/




- A. Казахстан, Астана
- B. Энэтхэг, Шинэ Дели
- C. Малайз, Куала-Лумпур
- D. Австрали, Сидней
- E. Египет, Кайр



44. Дундаж зузаан нь 35-45 км, 2-3 гр/см³ нягттай, эх газар, далайн ёроолын гэж хоёр хэсэгт хуваагддаг үе давхаргыг сонгоно уу. **/2 оноо/**

- A. Гадаад цөм В. Дээд манти С. Доод манти
D. Газрын давхарга Е. Дотоод цөм

45. Газарзүйн зурагт тодоор дүрсэлсэн улс, бүс нутгийг зөв тодорхойлно уу. **/2 оноо/**



- A. Египет, Зүүн Африк
B. Судан, Зүүн Африк
C. Чад, Төв Африк
D. Ливи, Хойд Африк
E. Египет, Хойд Африк

46. Монгол улсын Эрэнцав боомтоор аль улсын ямар нэртэй боомт хот руу шууд гарах вэ? **/2 оноо/**



- A. ОХУ-ын Цагаан толгой
B. БНХАУ-ын Сэхээ
C. ОХУ-ын Хиагт
D. БНХАУ-ын Ар хашаат
E. ОХУ-ын Соловьевск

47. БНХАУ-ын засаг захиргааны газарзүйн зурагт тодоор дүрслэгдсэн Өөртөө Засах Орны нэрийг олно уу. **/2 оноо/**



- A. Хөхнуур муж
B. Төвдийн Өөртөө Засах Орон
C. Өвөр Монголын Өөртөө Засах Орон
D. Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон
E. Ганьсү муж

48. Нутаг дэвсгэр, хүн амын тоо, хөлөг онгоц үйлдвэрлэлээр тавд, халуун орны мөнх ногоон ойн нөөц болон кофе, чихрийн нишингийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг улс аль нь вэ? **/2 оноо/**

- A. Бразил В. Индонез С. Хятад D. Польш Е. Финланд

49. Аймгуудыг төвтэй нь тохируулаарай. **/2 оноо/**

1	Сүхбаатар	a	Сайншанд
2	Дорноговь	b	Баруун-Урт
3	Дундговь	c	Цэцэрлэг
4	Архангай	d	Мандалговь

- A. 1-d, 2-c, 3-b, 4-a
B. 1-b, 2-d, 3-a, 4-c
C. 1-b, 2-a, 3-d, 4-c
D. 1-a, 2-b, 3-c, 4-d
E. 1-c, 2-a, 3-d, 4-b

50. Бэлчээрийн ургац 396 кг/га, нэг хонины хоногт идэх өвс 2,2 кг/га, бэлчээр ашиглах хугацаа 30 хоног бол ойт хээрийн бүсийн бэлчээрийн даацыг нэгж талбайд идээшлэх малын тоогоор тооцоолоорой. **/2 оноо/**

- A. 13 хонь В. 6 хонь С. 4 хонь D. 11 хонь Е. 66 хонь



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Хариултын хуудасны санамж 2-р хэсгийг анхааралтай уншиж танилцаарай.
2. Даалгаврын хариуг даалгавар тус бүр дэх зааврын дагуу гүйцэтгэнэ үү.

2.1. ЗУ 45°-д орших Багдад хотод Даваа гарагийн 06 цаг болж байхад БУ 165°-д орших Ном хотод ямар гарагийн хэдэн цаг болж байх вэ? **/6 оноо/**

Алхам

- гариг [а] [Даваа бол 1, Мягмар бол 2, Лхагва бол 3, Пүрэв бол 4, Баасан бол 5, Бямба бол 6, Ням бол 7 цифрээр төлөөлүүлэн тэмдэглээрэй] **/2 оноо/**
- цаг [bc] **/4 оноо/**


2.2. Сүхбаатар хотод цаг агаарын мэдээгээр агаарын даралт 798 гПа гэж зарласан бол А хотоос дээш хэдэн метр өндөрт оршиж байгааг бодож олоорой? (А хотод агаарын даралт 860 гПа)

Алхам

/6 оноо/


-агаарын даралтын зөрүү [ab], **/2 оноо/**

-хотын орших өндөр [cde] **/4 оноо/**



2.3. Өгөгдсөн дүрсийг ашиглан нуурын талбайг ойролцоогоор олж, км²-аар илэрхийлнэ үү.
Зургийн масштаб 1:200 000.

/6 оноо/



Алхам

-гурвалжингийн талбай [a] см², /2 оноо/

-тэгш өнцөгтийн талбай [bc] см², /2 оноо/

-масштаб ашиглаж олсон нуурын талбай [def] км²
/2 оноо/

2.4. Улсуудыг албан ёсны хэлтэй нь зөв харгалзуулна уу.

/6 оноо/

Улс орнууд		Хэл	
a.	Тайвань, Хонконг	1	Итали
b.	Ангол, Мозамбик	2	Испани
c.	Парагвай, Перу	3	Хятад
d.	Австрали, Ямаик	4	Араб
e.	Ватикан, Сан-Марино	5	Португал
f.	Ирак, Йемен	6	Англи

